



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 7 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар  
хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт  
оруулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:


“Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Улсын онцгой комиссын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар өөрчилсүгэй:

## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- |              |  |
|--------------|--|
| Дарга        | -Монгол Улсын Шадар сайд   |
| Орлогч дарга | -Батлан хамгаалахын сайд;<br>-Онцгой байдлын ерөнхий газрын дарга.   |
| Гишүүд:      | -Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;<br>-Барилга, хот байгуулалтын сайд;<br>-Зам, тээврийн хөгжлийн сайд;<br>-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд;<br>-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;<br>-Эрчим хүчний сайд;<br>-Эрүүл мэндийн сайд;<br>-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга;<br>-Нийслэлийн Засаг дарга;<br>-Хууль зүйн, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга; |

- Зэвсэгт хүчний жанжин штабын дарга;
- Тагнуулын ерөнхий газрын дарга;
- Хил хамгаалах ерөнхий газрын дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын дарга;
- Гаалийн ерөнхий газрын дарга;
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;
- Стандарт, хэмжил зүйн газрын дарга;
- Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга;
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга;
- Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга;
- Монголын улаан загалмайн нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга (тохиролцсоноор).
- Орон тооны.

Нарийн бичгийн  
дарга:



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Монгол Улсын Шадар сайд

У. ХҮРЭЛСҮХ